

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

ТОЙМ ДҮГНЭЛТ

Боловсруулсан:

Д. Баярмаа (ШУТИС-БуХС-ийн багш, докторант)

Хянан тохиолдуулсан: Д. Оюунбадам (PhD)

2016 оны 12-р сар

АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	1
НЭГ. МУ-ЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2016 ОНЫ 10-Р САРЫН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ.....	2
ХОЁР. 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ: НИЙТ ЗАРЛАГЫН ТОЙМ.....	6
ГУРАВ. 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ: УРСГАЛ ЗАРЛАГА.....	8
ДӨРӨВ. 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ: ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ.....	12
ТАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БА БСШУС-ЫН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ.....	16
ЗУРГАА. ТОЙМ ДҮГНЭЛТ.....	18

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БСШУС	–	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт
ДНБ	–	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	–	Засгийн газар
МУ	–	Монгол улс
НДШ	–	Нийгмийн даатгалын шимтгэл
ННФ	–	Нээлттэй нийгэм форум
УБ	–	Улаанбаатар
УЗ	–	Урсгал зардал
ХЗ	–	Хөрөнгийн зардал
ХХААХҮ	–	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэр
ҮАГ	–	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	–	Үндэсний Статистикийн Хороо
ЭТЦЗ	–	Эргэж төлөгдөх цэвэр зээл

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	2017 оны батлагдсан төсвийг 2016 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 20%-иас дээш өөрчлөлттэй байгаа зардлын нэр төрлүүд	11
Хүснэгт 2.	2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ (тойм)	14
Хүснэгт 3.	2017 онд Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)	14
Хүснэгт 4.	2017 онд Концессын гэрээгээр санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)	15

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар	2
Зураг 2.	Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар (салбараар)	3
Зураг 3.	Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар (хөтөлбөрөөр)	3
Зураг 4.	Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар (арга хэмжээгээр)	4
Зураг 5.	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (11-р сарын 30-ны байдлаар)	5
Зураг 6.	2010-2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	6
Зураг 7.	Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг өргөн барьсан төсөвтэй харьцуулсан үзүүлэлт	7
Зураг 8.	2017 оны батлагдсан төсвийн урсгал зарлага (2016 оны эхний ба тодотгосон төсөв, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулсан)	9
Зураг 9.	2017 оны батлагдсан төсвийн хөрөнгийн зардал (2016 оны эхний ба тодотгосон төсөв, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулсан)	12
Зураг 10.	2017 оны батлагдсан хөрөнгө оруулалт (эх үүсвэрээр)	13
Зураг 11.	Эрүүл мэндийн сайдын 2017 оны төсвийн зарлага	16
Зураг 12.	БСШУС-ын сайдын 2017 оны төсвийн зарлага	17
Зураг 13.	БСШУС-ын сайдын 2017 оны хөрөнгийн зардал	17

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын төсвийн алдагдал эрчимтэй нэмэгдэж, улмаар төсвийн төлөвлөлтийг сайжруулах асуудал хурцаар тавигдаж байна. Иймд Нээлттэй Нийгэм Форумас жил бүр Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд тойм шинжилгээ хийж үр дүнг нь бодлого боловсруулагчид, судлаачид, хэвлэл мэдээллийнхэн, иргэд, олон нийтэд танилцуулдаг. Тайлангийн үндсэн зорилго нь төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий байдлаар богино хугацаанд танилцуулж, хараат бус, хөндлөнгийн дүгнэлт өгөхөд оршино. Энэ жилээс эхлэн төсвийн төслөөс гадна УИХ-аас батлагдсан төсөвт тойм шинжилгээ хийж эхлээд байна.

Монгол Улсын 2017 оны батлагдсан төсвийн тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтаж байна. Үүнд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны 10-р сарын зарлагын гүйцэтгэл
- Монгол Улсын 2017 оны батлагдсан төсвийн нийт зарлагын тойм
- Монгол Улсын 2017 оны батлагдсан нэгдсэн төсвийн урсгал ба хөрөнгийн зардлын шинжилгээ
- Эрүүл мэндийн ба БСШУС-ын сайдын 2017 оны төсвийн зарцуулалт

Энэхүү танилцуулгыг боловсруулахдаа Сангийн яамны төсвийн мэдээллүүд, Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо, Эрүүл мэндийн яам, БСШУС-ын яам, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад олон улсын судалгааны байгууллагуудаас эмхтгэн гаргасан тайлангууд болон тоон мэдээллүүдэд тулгуурлав.

Энэхүү танилцуулга нь Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурь биш бөгөөд гагцхүү хувь судлаачийн байр суурийг илтгэнэ.

НЭГ. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2016 ОНЫ 10-Р САРЫН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 2016 оны 10-р сарын байдлаар 81.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2016 оны 10 дугаар сарын байдлаар 8.35 их наяд төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 6.81 их наяд төгрөгийн буюу 81.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Зардлын төрөл тус бүрээр авч үзвэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл(НДШ)-ийн зардал 97.5%, бараа, үйлчилгээний бусад зардал 83.9%, хүүгийн зардал 74.0%, татаас 77.4%, урсгал шилжүүлэг 94.8%-ийн гүйцэтгэлтэй буюу нийт урсгал зардлын гүйцэтгэл 89.7% байгаа бол хөрөнгийн зардлын гүйцэтгэл 58.5% байна (Зураг 1).

Зураг 1. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол


Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл 1.33 их наяд төгрөгөөр буюу 24.5%-иар өссөн байна. Энэ өсөлтөд өмнөх онтой харьцуулахад бараа ажил үйлчилгээний зардал 15.8%, зээлийн үйлчилгээний төлбөр 37.3%, татаас 48.6%, урсгал шилжүүлэг 13.1%, хөрөнгийн зардал 13.5%-иар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг салбараар авч үзвэл тээвэр холбооны салбарын гүйцэтгэл хэтэрсэн, эрчим хүч, дулаан хангамжийн салбарын гүйцэтгэл хамгийн бага байна.

Тээвэр холбооны салбарын гүйцэтгэл хэтэрч 113.1%-д хүрсэн бол эрчим хүч, дулаан хангамжийн салбарын гүйцэтгэл 29%-тай байна (Зураг 2). Эрүүл

мэндийн салбарын зарлагын гүйцэтгэл 89.4%, боловсролын салбарын гүйцэтгэл 82.3%-тай байна. Бусад салбаруудын хувьд 59.6-98.8%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 2. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар (салбараар)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг хөтөлбөрөөр авч үзвэл нийгмийн хамгааллын хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл хамгийн өндөр, эрчим хүч, уул уурхайн хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл хамгийн бага байна.

Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл 95.9% байгаа бол эрчим хүч, уул уурхайн хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл 44.9%-ийн гүйцэтгэлтэй байна (Зураг 3). Эрүүл мэндийн хөтөлбөрийн зардлын гүйцэтгэл 89.3%, Боловсрол, шинжлэх ухааны хөтөлбөрийн гүйцэтгэл 85.2% байна. Бусад хөтөлбөрүүдийн хувьд 46.5-93.4%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 3. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар (хөтөлбөрөөр)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг арга хэмжээгээр авч үзвэл нийгмийн даатгалын шилжүүлгийн зориулалтын зардлын гүйцэтгэл хамгийн өндөр, хувь эзэмшил, санхүүгийн хөрөнгө оруулалтын зориулалтын зардлын гүйцэтгэл хамгийн бага байна. Нийгмийн даатгалын шилжүүлгийн зориулалтын зардлын гүйцэтгэл 100.5% байгаа бол хувь эзэмшил, санхүүгийн хөрөнгө оруулалтын зориулалтын зардлын гүйцэтгэл 0.2%-ийн гүйцэтгэлтэй байна (Зураг 4). Эрүүл мэндийн арга хэмжээний зардлын гүйцэтгэл 65.5%, Боловсролын арга хэмжээний зардлын гүйцэтгэл 82.7% байна. Бусад арга хэмжээнүүдийн хувьд 2.7-98.3%-ийн гүйцэтгэлтэй байна.

Зураг 4. Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл 2016 оны 10-р сарын байдлаар (арга хэмжээгээр)




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 11 сарын эцсийн байдлаар 51.8%-ийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын 2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт 1.04 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2016.11.30-ны байдлаар 0.54 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдэж, 51.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл улсын ерөнхий прокурорын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарлагын гүйцэтгэл хамгийн өндөр буюу 100%, МУ-ын ерөнхий аудиторын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний

гүйцэтгэл хамгийн бага буюу 8.1% байна (Зураг 5). Эрүүл мэндийн сайдын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарлагын гүйцэтгэл 91.8% байгаа бол БСШУС-ын сайдын гүйцэтгэл 66.1%-тай байна. Бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 20.4-93.1%-тай байна.

Зураг 5. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (11-р сарын 30-ны байдлаар)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол


ХОЁР. 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ: НИЙТ ЗАРЛАГЫН ТОЙМ

2017 оны нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад 4.9 тэрбум төгрөг буюу 0.06%-иар өссөн дүнтэйгээр баталжээ.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 8.57 их наяд төгрөг байхаар баталсан. Энэ нь 2016 оны батлагдсан эхний төсөвтэй харьцуулахад 614.5 тэрбум төгрөгөөр буюу 7.7%-иар, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад 4.9 тэрбум төгрөгөөр буюу 0.06%-иар өссөн байна (Зураг 6). Харин 2016 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулахад 1125.5 тэрбум төгрөгөөр буюу 11.6%-иар буурсан байна

2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл ДНБ-ний 32.3%-тай тэнцүү байхаар байна. Нийт зарлагын 81.1% буюу 6.95 их наяд төгрөгийг урсгал зардалд, 17.3% буюу 1.48 их наяд төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Зураг 6. 2010-2017 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Батлагдсан төсвийг өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад Улсын ерөнхий прокурор Үндсэн хуулийн цэцийн дарга, Их хурлын дарга, Ерөнхий сайд нарын төсвийн зарлагад харьцангуй их хэмжээний өөрчлөлт гарчээ.

2017 оны батлагдсан төсвөөрх төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн нийт зарлагыг УИХ-д өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулан авч үзвэл дараах өөрчлөлтүүд гарчээ. Хамгийн өндөр өсөлттэй зарлагад Улсын ерөнхий прокурорын зарлага (9.29 тэрбум төгрөг буюу 55.4%-иар), Үндсэн хуулийн цэцийн даргын зарлага (0.3 тэрбум төгрөг буюу 26.4%-иар), Их хурлын

даргын зарлага (4.0 тэрбум төгрөг буюу 17.1%-иар) багтаж байна (Зураг 7). Хууль зүй дотоод хэргийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайд, ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайд нарын зарлага 1.4-5.8%-иар өсчээ. Харин Ерөнхий сайдын төсвийн зарлага 35.9 тэрбум төгрөг буюу 18%-иар, Эрчим хүчний сайдын төсвийн зарлага 4.8 тэрбум төгрөг буюу 4.2%-иар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн зарлага 1.2 тэрбум төгрөг буюу 2.6%-иар буурсан байна. Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн зарлагын хувьд харьцангуй бага (1%-иас доош) өөрчлөлт гарчээ. БСШУС-ын сайдын төсвийн зарлагыг 4.1 тэрбум төгрөг буюу 0.3%-иар, Эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагыг 0.8 тэрбум төгрөг буюу 0.1%-иар тус тус бууруулан баталжээ.

Зураг 7. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг өргөн барьсан төсөвтэй харьцуулсан үзүүлэлт



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

ГУРАВ. 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ: УРСГАЛ ЗАРЛАГА

Урсгал зардлын хэмжээг өргөн барьсан төсвийн төсөлд тусгасан хэмжээнээс өсгөж баталсан. Нэгдсэн төсвийг батлахдаа өргөн барьсан төсөв дэх өмнөх онтой харьцуулахад өндөр өсөлттэй байсан урсгал зардлуудыг дахин хянаж, бууруулах арга хэмжээ аваагүй.

2017 оны нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагыг 6.95 их наяд төгрөгөөр баталсан бөгөөд энэ нь 2016 оны батлагдсан эхний төсөвтэй харьцуулахад 725.1 тэрбум төгрөгөөр буюу 11.65%-иар, 2016 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулахад 231.0 тэрбум төгрөгөөр буюу 3.44%-иар, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад 10.5 тэрбум төгрөгөөр буюу 0.15%-иар тус тус өссөн байна.

Энэ нь нэгдсэн төсвийг батлахдаа өргөн барьсан төсөв дэх өмнөх онтой харьцуулахад өндөр өсөлттэй байсан урсгал зардлуудыг дахин хянаж үзэн, бууруулах арга хэмжээ аваагүй болохыг харуулж байна. Өргөн барьсан төсөвтэй харьцуулахад бараа үйлчилгээний зардлыг 1.8%-иар, урсгал шилжүүлгийг 0.09%-иар өсгөж баталсан байна. Харин цалин хөлсийг 0.37%-иар, зээлийн үйлчилгээний төлбөрийг 0.62%-иар бууруулж баталжээ.

Сүүлийн жилүүдэд урсгал зардлын тэлэлт үргэлжилсээр байгаа бөгөөд ҮСХ-оос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар хүн амын насжилт нэмэгдэж, нийт хүн ам дахь тэтгэврийн насны хүн амын тоо нэмэгдэж байгаа нь төсвийн урсгал зарлагын дарамтыг улам нэмэгдүүлэхээр байна.

Урсгал зардлын өсөлтөд зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт голлон нөлөөлжээ.

2017 оны урсгал зарлагыг зардлын төрөл тус бүрээр өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад зардлын төрөл тус бүр өсөлттэй гарчээ. Тухайлбал, зээлийн үйлчилгээний төлбөр 28.4%, цалин хөлс 1.5%, урсгал шилжүүлэг 2.2%-иар тус тус өсч, бараа үйлчилгээний зардал 9.2%-иар, татаас 5.2%-иар тус тус буурчээ (Зураг 8). Харин 2016 оны эхний төсөвтэй харьцуулахад цалин хөлс 2.99%, бараа үйлчилгээний зардал 3.9%, зээлийн үйлчилгээний төлбөр 41.99%, урсгал шилжүүлэг 9.4%, татаас 15.2%-иар өсчээ. Үүнээс харахад урсгал зардлын өсөлтөд зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт голлон нөлөөлж байна. Урсгал зардлын өсөлтийг хязгаарлахын тулд Засгийн газрын зүгээс төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимоор ажиллах, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн түвшинг хадгалах, зээлийн хүүгийн зардлын өсөлтийг хязгаарлах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах зарчим баримтална гэж төлөвлөж байсан боловч өндөр өсөлттэй зарим төрлийн урсгал зардлууд байгааг зардлын дэлгэрэнгүйгээс харж болно (Хавсралт 1).

Зураг 8. 2017 оны батлагдсан нэгдсэн төсвийн урсгал зарлага (2016 оны эхний ба тодотгосон төсөв, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулсан)

УРСГАЛ ЗАРЛАГА (ИХ НАЯД ТӨГРӨГ)	2017 БАТ/2016 ТӨЛ	2017 БАТ/2016 ТОД	2017 БАТ/2017 ТӨС
ЦАЛИН ХӨЛС  1.74	 2.99%	 1.49%	 -0.37%
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  1.31	 3.89%	 -9.18%	 1.80%
ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР  1.35	 41.99%	 28.42%	 -0.62%
ТАТААС  0.19	 15.19%	 -5.22%	 0.00%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  2.37	 9.36%	 2.17%	 0.09%
НИЙТ УРСГАЛ ЗАРЛАГА  6.95	 11.65%	 3.44%	 0.15%
 Өсөлт %  Бууралт %			

Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Нийт урсгал зардлын бүтцэд цалин хөлс ба урсгал шилжүүлгийн зардал өндөр хувь эзэлж байна.

Нийт урсгал зарлагыг бүтцээр нь авч үзвэл цалин хөлс 24.98%, бараа үйлчилгээний бусад зардал 18.8%, зээлийн үйлчилгээний төлбөр 19.4%, татаас 2.75%, урсгал шилжүүлэг 34.1%-ийг эзэлж байна. Урсгал зардлыг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, НДШ-ийн зардлын 72.8%-ийг үндсэн цалин, 12.2%-ийг нэмэгдэл цалин, 8.3%-ийг ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл, 2.1%-ийг унаа хоолны хөнгөлөлт, 2.4%-ийг урамшуулал, 2.2%-ийг гэрээт ажлын цалин эзэлж байна.

Бараа, үйлчилгээний зардлын 18.75%-ийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 5.4%-ийг хангамж, бараа материалын зардал, 19.7%-ийг нормативт зардал, 2.1%-ийг эд хогшил, урсгал засварын зардал, 1.4%-ийг томилолт зочны зардал, 32.7%-ийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 19.95%-ийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлжээ. Зээлийн үйлчилгээний төлбөрийн 39.4%-ийг гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, 60.6%-ийг дотоод зээлийн үйлчилгээний төлбөр, Засгийн газрын урсгал шилжүүлгийн 99.6%-ийг дотоод шилжүүлэг, 0.4%-ийг гадаад шилжүүлэг эзэлж байна.

2017 оны батлагдсан төсвийн урсгал зардлыг зардлын дэлгэрэнгүй нэр төрөл бүрээр 2016 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулахад хамгийн өндөр өсөлттэй байгаа зардлуудад нэмэгдэл цалин, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардал багтаж байна. 2016 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулж үзвэл, 20%-иас дээш буюу өндөр өсөлттэй зардлуудад дараах зардлууд багтаж байна. Үүнд: нэмэгдэл цалин 84%-иар, тэтгэмжийн даатгал 24.6%, ном хэвлэл 115.1%, хөдөлмөр хамгааллын хэрэглэл 44.8%, мэдээллийн технологийн үйлчилгээ 24.8%, газрын төлбөр 23.9%, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 37.6%, гадаад зээлийн үйлчилгээний төлбөр 55.1%, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 61.3%, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 127.6%-иар тус тус өсчээ (Хүснэгт 1).

**Хүснэгт 1. 2017 оны батлагдсан төсвийг 2016 оны тодотгосон
төсөвтэй харьцуулахад 20%-иас дээш өөрчлөлттэй байгаа зардлын нэр
төрлүүд**

Зардлын нэр төрөл (дэлгэрэнгүй)	2017 оны батлагдсан төсвийн урсгал зарлага (тэрбум төг)	2017 бат/2016 год		2017 бат/2017 төс	
		Абсолют өөрчлөлт (тэрбум төг)	Өөрчлөлт %	Абсолют өөрчлөлт (тэрбум төг)	Өөрчлөлт %
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал					
Нэмэгдэл	231.7	105.8	84.0%	0.1	0.0%
Урамшуулал	45.0	-15.7	-25.9%	-0.5	-1.0%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл					
Тэтгэмжийн даатгал	13.6	2.7	24.6%	-0.1	-0.4%
Хангамж, бараа материалын зардал					
Ном, хэвлэл	6.1	3.3	115.1%	0.0	-0.6%
Эд хогшил, урсгал засварын зардал					
Тавилга	0.0	-2.5	-100.0%	0.0	
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.0	0.3	44.8%	0.0	-1.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр					
Мэдээллийн технологийн үйлчилгээ	6.8	1.4	24.8%	-0.1	-1.4%
Газрын төлбөр	1.4	0.3	23.9%	0.0	-1.4%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1.9	-12.6	-86.7%	0.0	-0.7%
Бараа үйлчилгээний бусад зардал					
Бараа үйлчилгээний бусад зардал	233.5	-167.8	-41.8%	15.5	7.1%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27.4	7.5	37.6%	1.7	6.7%
Хүү					
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	530.5	188.4	55.1%	39.3	8.0%
Бусад урсгал шилжүүлэг					

Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	-0.1	-100.0%	0.0	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.4	0.1	61.3%	0.0	0.0%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалт	5.5	-10.1	-64.8%	0.1	2.3%
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	57.9	32.5	127.6%	0.0	0.0%

Харин зардлын таналт хийгдсэн буюу 20%-иас дээш хувиар буурсан зардлуудад дараах зардлууд багтаж байна. Үүнд: урамшуулал 25.9%, тавилга 100%, банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж 86.7%, ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт 100%, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал 64.8%-иар тус тус буурчээ. (Зардлын дэлгэрэнгүй үзүүлэлтийг Хавсралт 1-ээс үзнэ үү)

ННФ-аас 2017 оны нэгдсэн төсвийн төслийн зарлагын төлөвлөлтөд хийсэн тойм дүгнэлтээр өндөр өсөлттэй байгаа зардлын нэр төрлүүд (нэмэгдэл цалин, тэтгэмжийн даатгал, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, мэдээллийн технологийн үйлчилгээ, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэг г.м)-ийг дахин хянан үзэж бууруулахыг санал болгож байсан боловч төсвийн төсөл ба батлагдсан төсөв хоорондын зөрүү бага байна. Тухайлбал, дахин хянаж үзэхийг санал болгож байсан зардлын төрлүүдээс тэтгэмжийн даатгал, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлуудыг 0.4-1.4% хүртэлх хэмжээгээр л бууруулж баталжээ.

Батлагдсан төсвөөрх урсгал зардлын нэр төрөл тус бүрийг өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад дотоод зээлийн үйлчилгээний төлбөрийг 5.5%-иар, урсгал засварын зардлыг 3.5%-иар, нормын хувцсыг 3.2%-иар, тээврийн хэрэгслийн татварыг 3.2%-иар бууруулж баталсан нь хамгийн өндөр хувиар бууруулж баталсан зардлуудад багтаж байна.


ДӨРӨВ. 2017 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСӨВ: ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

Хөрөнгийн зардлын хэмжээг өргөн барьсан төслийн хэмжээнээс бууруулж баталсан. Нийт зардлын өсөлтийг хязгаарлах зорилтыг хөрөнгийн зардлыг бууруулах замаар шийдвэрлэхийг оролдсон.

2017 оны нэгдсэн төсвийн нийт хөрөнгийн зардлыг 1.48 их наяд төгрөгөөр баталсан бөгөөд энэ нь 2016 оны батлагдсан эхний төсөвтэй харьцуулахад 446.6 тэрбум төгрөгөөр буюу 23.1%-иар буурсан, 2016 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулахад 866.2 тэрбум төгрөгөөр буюу 36.9%-иар буурсан, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад 10.3 тэрбум төгрөгөөр буюу 0.7%-иар тус тус буурсан дүнтэй байна (Зураг 9).

Хөрөнгийн зардлыг төрөл тус бүрээр нь өмнөх оны тодотголоор батлагдсан түвшинтэй харьцуулахад их засварын зардал 29.6%, стратегийн нөөц хөрөнгө 101.2%-иар өссөн бол барилга байгууламжийн зардал 52.1%, тоног төхөөрөмжийн зардал 68.4%, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт 44.5%-иар буурчээ. Харин 2016 оны эхний төсөвтэй харьцуулахад их засварын зардал 41.35%, стратегийн нөөц хөрөнгө 101.2%-иар өсч, барилга байгууламжийн зардал 10.7%, тоног төхөөрөмжийн зардал 33.9%, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт 51.8%-иар буурчээ.

Зураг 9. 2017 оны батлагдсан төсвийн хөрөнгийн зардал (2016 оны эхний ба тодотгосон төсөв, 2017 оны өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулсан)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол


Нийт хөрөнгийн зардлыг бүтцээр нь авч үзвэл барилга байгууламж 42.8%, их засвар 3.9%, тоног төхөөрөмж 6.1%, бусад хөрөнгө 33.5%, стратегийн нөөц

хөрөнгө 2.5%, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт 11.6%-ийг тус тус эзэлж байна.

2017 онд төсвийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 60 гаруй хувиар буурна.

Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Улсын төсөв, Хөгжлийн банк, концесс, векселийн хөрөнгө оруулалтуудыг нэгтгэн нэгдсэн төсөвтэй болсон. 2017 онд нийт 495 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт баталсан бөгөөд энэ нь 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 63.5%-иар, 2017 оны төсвийн төсөлтэй харьцуулахад 9.5%-иар буурсан үзүүлэлт юм (Зураг 10). Нийт хөрөнгө оруулалтын 50.6%-ийг улсын төсвөөс, 34.9%-ийг төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны эх үүсвэрээр, 14.4%-ийг концессийн гэрээгээр санхүүжүүлэхээр баталжээ.

Зураг 10. 2017 оны батлагдсан хөрөнгө оруулалт (эх үүсвэрээр)



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад өөрчлөлт орж батлагджээ.

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд 184 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг нийт 250.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан. Өргөн барьсан хуулийн төсөлд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, байгууламжийн жагсаалтад зарим өөрчлөлтийг хийж баталсан. Тухайлбал, Барилга, хот байгуулалтын сайдын Монгол Улсын хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах (Улсын хэмжээнд) болон БСШУС-ын сайдын Соёлын төвийн барилга (Увс аймгийн

Зүүнговь сум) төслүүд хасагдсан. Харин ХХААХҮ-ийн сайдын Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга (Баянхонгор аймгийн Баянхонгор сум), Хүнс барааны худалдааны төвийн барилга (Хөвсгөл аймгийн Мөрөн сум), Эрүүл мэндийн сайдын Хавдар судлалын үндэсний төвийн сити томографын аппарат (Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг) төслүүд нэмэгдсэн. Мөн зарим төслүүдийн улсын төсвөөс санхүүжих дүнг бууруулж баталсан.

Хүснэгт 2. 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ (тойм)

ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ОН	2006 онд 1 төсөл, 2008 онд 3 төсөл, 2009 онд 1 төсөл, 2010 онд 10 төсөл, 2011 онд 20 төсөл, 2012 онд 48 төсөл, 2013 онд 38 төсөл, 2014 онд 21 төсөл, 2015 онд 12 төсөл, 2016 онд 23 төсөл тус тус хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2017 онд 7 төсөл шинээр хэрэгжиж эхэлнэ.
ХЭРЭГЖИЖ ДУУСАХ ОН	2017 онд 126 төсөл, 2018 онд 46 төсөл, 2019 онд 9 төсөл, 2020 онд 3 төсөл хэрэгжиж дуусна.
ХАМГИЙН ӨНДӨР САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Нэгдсэн хорих анги, инженерийн байгууламж, 1500 хүн /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, 12.1 тэрбум төгрөг
ХАМГИЙН БАГА САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Ахмадын ордны барилга /Завхан, Улиастай сум/, 2.2 сая төгрөг

Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад өөрчлөлт ороогүй.

Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 2017 онд нийт 119 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 172.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ. Эдгээр нь бүгд шилжих төсөл, арга хэмжээ байна. Өргөн барьсан хуулийн төсөлд Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөж байсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, байгууламжийн жагсаалтыг хэвээр нь баталсан.

Хүснэгт 3. 2017 онд Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)

ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ОН	2011 онд 2 төсөл, 2012 онд 7 төсөл, 2013 онд 20 төсөл, 2014 онд 73 төсөл, 2015 онд 12 төсөл, 2016 онд 5 төсөл тус тус хэрэгжиж эхэлжээ.
ХЭРЭГЖИЖ ДУУСАХ ОН	2017 онд 109 төсөл, 2018 онд 10 төсөл хэрэгжиж дуусна.

ХАМГИЙН ӨНДӨР САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Олон улсын шинэ нисэх буудал барихтай холбогдуулан монголын талын гүйцэтгэх төсөл, арга хэмжээ Засгийн газрын 2015 оны 313 тоот тогтоолын хүрээнд хийгдэх авто зам, /Төв, Хөшигийн хөндий/, 17.3 тэрбум төгрөг
ХАМГИЙН БАГА САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт, удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил, 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 км шилэн кабель бүхий аянгын тростой цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил, 5.7 сая төгрөг

Барих шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас зарим төсөл, арга хэмжээ хасагдсан.

“Барих-шилжүүлэх” концессын төрлөөр 2017 онд 12 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг нийт 71.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлнэ. Өргөн барьсан хуулийн төсөлд Концессын төрлөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, байгууламжийн жагсаалтаас 3 төсөл, арга хэмжээг хасч баталсан. Үүнд, Сэлэнгэ аймгаар өнгөрөх олон улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих төсөл, Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд орших 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих төсөл, Төрийн тусгай хамгаалалтын газарт материал илрүүлэгч рентген төхөөрөмж нийлүүлэх төсөл хасагджээ.

Хүснэгт 4. 2017 онд Концессын гэрээгээр санхүүжих хөрөнгө оруулалт (тойм)


ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН ОН	2015 онд 5 төсөл, 2016 онд 7 төсөл тус тус хэрэгжиж эхэлжээ.
ХЭРЭГЖИЖ ДУУСАХ ОН	2017 онд 7 төсөл, 2018 онд 3 төсөл, 2019 онд 2 төсөл хэрэгжиж дуусна.
ХАМГИЙН ӨНДӨР САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам, 16.1 тэрбум төгрөг
ХАМГИЙН БАГА САНХҮҮЖИЛТТЭЙ ТӨСӨЛ	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор/, 0.8 тэрбум төгрөг

ТАВ. ЭРҮҮЛ МЭНД БА БСШУС-ЫН САЙДЫН 2017 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Эрүүл мэнд ба БСШУС-ын сайдын төсвийн зарлагын хэмжээг өргөн барьсан төслийн хэмжээнээс бууруулж баталсан.

2017 оны батлагдсан төсвөөр эрүүл мэндийн сайдын төсвийн зарлагыг өргөн барьсан төслөөс 0.9 тэрбум төгрөгөөр бууруулж, 654.0 тэрбум төгрөгөөр тооцож баталсан. Үүний 87% буюу 568.9 тэрбум төгрөг нь урсгал зардал, 5.5% буюу 35.9 тэрбум төгрөг нь хөрөнгийн зардал, 7.5% буюу 49.1 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал байна (Зураг 11).

Зураг 11. Эрүүл мэндийн сайдын 2017 оны төсвийн зарлага




Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2017 онд МУ-ын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрүүл мэндийн сайдын хөрөнгийн зардлыг нийт 35.9 тэрбум төгрөгөөр баталсан. Үүний 64.9% буюу 23.3 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 8.4% буюу 3 тэрбум төгрөг нь их засварын зардал, 26.7% буюу 9.6 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмжийн зардал байна. Эрүүл мэндийн салбарт 2017 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний 30.6% буюу 11.0 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжиж эхлэх төсөл, арга хэмжээ, 69.4% хувь буюу 24.9 тэрбум төгрөг нь өмнөх оноос шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ байхаар баталжээ.

2017 оны батлагдсан нэгдсэн төсөвт БСШУС-ын сайдын төсвийн зарлагыг өргөн барьсан төслөөс 4.2 тэрбум төгрөгөөр бууруулж, 1357.5 тэрбум төгрөгөөр тооцож баталсан. Үүний 76.7% буюу 1041 тэрбум төгрөгийг урсгал зардал, 7.1% буюу 96.3 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал, 7.7% буюу 104.5 тэрбум төгрөгийг дотоод эх үүсвэрээс олгох зээл, 8.5% буюу 115.7 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал эзэлж байна.


Зураг 11. БСШУС-ын сайдын 2017 оны төсвийн зарлага



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

2017 онд МУ-ын төсвийн хөрөнгөөр БСШУС-ын сайдын хөрөнгийн зардлыг нийт 96.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. Үүнээс 82.8% буюу 79.8 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалт, 5.8% буюу 5.6 тэрбум төгрөг нь их засварын зардал, 11.4% буюу 11 тэрбум төгрөг нь тоног төхөөрөмжийн зардал байна. БСШУС-ын сайдын хөрөнгийн зардлыг салбараар нь авч үзвэл 71.5% буюу 68.9 тэрбум төгрөгийг боловсролын, 16.7% буюу 16.1 тэрбум төгрөгийг соёл урлагын, 0.9% буюу 0.9 тэрбум төгрөгийг шинжлэх ухааны, 10.9% буюу 10.5 тэрбум төгрөгийг спортын салбарт тус тус зарцуулахаар баталжээ (Зураг 12).

Зураг 12. БСШУС-ын сайдын 2017 оны хөрөнгийн зардал



Эх сурвалж: Сангийн яам, Судлаачийн тооцоолол

ЗУРГАА. ТОЙМ ДҮГНЭЛТ

2017 оны батлагдсан төсвийн зарлагын төлөвлөлтөд хийсэн тойм судалгааны дүнг хураангуйлан дүгнэвэл:

Урсгал зардлын онцлог:

- Урсгал зардлын хэмжээг өргөн барьсан төсвийн хэмжээнээс өсгөж баталсан.
- Урсгал зардлын хэмжээ өмнөх оны эхний ба тодотгосон төсөвтэй харьцуулахад өсчээ.
- Батлагдсан төсвийг өргөн барьсан төсвийн төсөлтэй харьцуулахад Улсын ерөнхий прокурор, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын их хурлын дарга, Ерөнхий сайд нарын төсвийн зарлагад харьцангуй их хэмжээний өөрчлөлт гарчээ.
- Нэгдсэн төсвийг батлахдаа өргөн барьсан төсөв дэх өмнөх онтой харьцуулахад өндөр өсөлттэй байсан урсгал зардлуудыг дахин хянаж, бууруулах арга хэмжээ аваагүй.
- Урсгал зардлын өсөлтөд зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт голлон нөлөөлжээ.
- Нийт урсгал зардлын бүтцэд цалин хөлс ба урсгал шилжүүлгийн зардал өндөр хувь эзэлж байна.
- 2016 оны тодотголоор батлагдсан төсөвтэй харьцуулахад хамгийн өндөр өсөлттэй байгаа зардлуудад нэмэгдэл цалин, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэглэл, гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн зардал багтаж байна.

Хөрөнгийн зардлын онцлог::

- Хөрөнгийн зардлыг өргөн барьсан төсвийн хэмжээнээс бууруулж баталсан.
- Нийт зардлын өсөлтийг хязгаарлах зорилтыг хөрөнгийн зардлыг бууруулах замаар шийдвэрлэхийг оролдсон.
- Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан.
- Засгийн газрын зүгээс хөрөнгө оруулалтын шинэ арга хэмжээ эхлүүлэхгүй байх зарчим баримтална гэсэн боловч шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг төсөвт тусгажээ.
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад өөрчлөлт орж батлагдсан.
- Хөгжлийн банкны эх үүсвэрээр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад өөрчлөлт ороогүй.
- Барих шилжүүлэх концессын төрлөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас зарим төсөл, арга хэмжээ хасагдан батлагджээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын 2017 оны төсвийн төслийн баримт бичгүүд (төсвийн хуулийн төслүүд, төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга)
2. 2010-2016 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангууд
3. Үндэсний Аудитын Газар (2016). *Монгол улсын 2016 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт*
4. Дэлхийн банкны индикатор үзүүлэлтүүд
5. Эрүүл мэндийн яамны статистик мэдээлэл, тайлан
6. БСШУС-ын яамны статистик мэдээлэл, тайлан
7. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны мэдээллүүд
8. Бусад

Хавсралт 1. 2017 оны батлагдсан төсвийн урсгал зардлын дэлгэрэнгүй (2016 оны тодотгосон төсөв ба 2017 оны төсвийн төсөлтэй харьцуулсан)

Зардлын нэр төрөл (дэлгэрэнгүй)	2017 оны батлагдсан төсвийн урсгал зарлага (тэрбум төг)	2017 бат/2016 тод		2017 бат/2017 төс	
		Абсолют өөрчлөлт (тэрбум төг)	Өөрчлөлт %	Абсолют өөрчлөлт (тэрбум төг)	Өөрчлөлт %
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1735.7	25.5	1.5%	-6.5	-0.4%
Үндсэн цалин	1378.5	-67.4	-4.7%	-5.5	-0.4%
Нэмэгдэл	231.7	105.8	84.0%	0.1	0.0%
Унаа хоолны хөнгөлөлт	39.3	1.5	3.9%	-0.4	-1.0%
Урамшуулал	45.0	-15.7	-25.9%	-0.5	-1.0%
Гэрээт ажлын цалин	41.2	1.4	3.5%	-0.2	-0.5%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	157.8	0.6	0.4%	-0.5	-0.3%
Тэтгэврийн даатгал	96.0	0.4	0.4%	-0.2	-0.3%
Тэтгэмжийн даатгал	13.6	2.7	24.6%	-0.1	-0.4%
ҮОМШ-ний даатгал	11.1	-2.6	-18.8%	0.0	-0.4%
Ажилгүйдлийн даатгал	2.7	0.0	-0.9%	0.0	-0.4%
Эрүүл мэндийн даатгал	34.3	0.1	0.2%	-0.2	-0.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	245.2	7.1	3.0%	-2.1	-0.8%
Гэрэл, цахилгаан	45.7	1.4	3.2%	-0.6	-1.4%
Түлш, халаалт	155.0	2.9	1.9%	-1.7	-1.1%
Цэвэр, бохир ус	26.4	1.0	4.0%	-0.3	-1.1%
Байрны түрээс	18.0	1.9	11.5%	0.5	3.1%
Хангамж, бараа материалын зардал	71.0	2.4	3.5%	-0.8	-1.2%
Бичиг хэрэг	7.9	0.9	12.7%	0.0	-0.3%
Тээвэр, шатахуун	37.2	-1.8	-4.6%	-0.5	-1.2%
Шуудан холбоо, интернетийн төлбөр	9.7	0.0	0.0%	-0.1	-1.4%
Ном, хэвлэл	6.1	3.3	115.1%	0.0	-0.6%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	4.3	0.1	2.7%	-0.1	-1.4%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5.8	0.0	-0.5%	-0.1	-1.7%
Нормативт зардал	257.6	-7.0	-2.6%	-3.5	-1.4%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	116.2	1.4	1.2%	-1.2	-1.0%
Хоол, хүнс	114.4	-3.8	-3.2%	-1.5	-1.3%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	27.0	-4.5	-14.3%	-0.9	-3.2%
Эд хогшил, урсгал засварын зардал	27.6	-5.4	-16.3%	-0.8	-2.8%
Багаж, техник, хэрэгсэл	7.4	-0.7	-8.8%	-0.1	-1.2%
Тавилга	0.0	-2.5	-100.0%	0.0	
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.0	0.3	44.8%	0.0	-1.0%
Урсгал засвар	19.2	-2.4	-11.2%	-0.7	-3.5%
Томилолт, зочны зардал	18.0	-0.3	-1.5%	-0.1	-0.7%
Гадаад албан томилолт	5.8	0.9	17.8%	0.0	0.1%
Дотоод албан томилолт	10.9	-1.0	-8.2%	-0.2	-1.6%
Зочин төлөөлөгч хүлээн авах	1.3	-0.2	-11.6%	0.0	3.7%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	427.2	31.3	7.9%	0.0	0.0%

үйлчилгээний төлбөр					
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	393.1	40.1	11.4%	13.4	3.5%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1.5	-0.1	-3.8%	0.0	-1.0%
Даатгалын үйлчилгээ	9.9	0.7	7.8%	0.3	2.7%
Тээврийн хэрэгслийн татвар	0.6	-0.1	-8.6%	0.0	-3.2%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.2	0.0	-0.6%	0.0	-1.6%
Мэдээллийн технологийн үйлчилгээ	6.8	1.4	24.8%	-0.1	-1.4%
Газрын төлбөр	1.4	0.3	23.9%	0.0	-1.4%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1.9	-12.6	-86.7%	0.0	-0.7%
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11.8	1.5	15.0%	-0.1	-1.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	260.9	-160.3	-38.1%	17.2	7.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	233.5	-167.8	-41.8%	15.5	7.1%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27.4	7.5	37.6%	1.7	6.7%
Хүү	1345.7	297.9	28.4%	-8.3	-0.6%
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	530.5	188.4	55.1%	39.3	8.0%
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	815.2	109.5	15.5%	-47.6	-5.5%
Татаас	191.0	-10.5	-5.2%	0.0	0.0%
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1704.3	52.3	3.2%	0.3	0.0%
Засгийн газрын дотоод шилжүүлэг	1697.7	51.6	3.1%	0.2	0.0%
Засгийн газрын гадаад шилжүүлэг	6.7	0.7	12.0%	0.1	1.6%
Бусад урсгал шилжүүлэг	2285.8	30.6	1.4%	2285.8	
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	1574.7	100.5	6.8%	0.0	0.0%
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	-0.1	-100.0%	0.0	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	88.9	-7.5	-7.8%	-0.7	-0.8%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.4	0.1	61.3%	0.0	0.0%
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	449.5	-68.6	-13.2%	2.7	0.6%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалт	5.5	-10.1	-64.8%	0.1	2.3%
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	57.9	32.5	127.6%	0.0	0.0%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	109.0	-16.2	-13.0%	-0.1	-0.1%